

**2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 03 дугаар сарын 27-ны “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД /Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28, 03 дугаар сарын 06-ны өдрүүдийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар/		
1	Дүүргийн нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, эдийн засгийн нөөц, чадавхид тулгуурлан хөгжүүлэх тухай баримт бичгийг боловсруулж танилцуулах.	ТЗУХ
2	Дүүргийн хүн амын өсөлттэй уялдуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлыг судлан, авах арга хэмжээний санал танилцуулах.	НХХ, ЭМТ
3	Хог ангилан ялгах, хаягдлыг сэргээн ашиглах талаар арга хэмжээг хэрэгжүүлэх.	Багахангай ОНӨААТҮГ
4	Гэр хорооллын хороодод ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор бүсийн нэмэгдлийг тооцож олгох боломжийг судалж, танилцуулах.	ТЗУХ
5	Хорооны Засаг дарга нарын эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлэх талаарх асуудлыг судалж танилцуулах.	ТЗУХ
6	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн байгууллагуудын өмчлөлийн газрыг хууль бусаар бусдын эзэмшилд шилжүүлсэн талаарх мэдээллийг нэгтгэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, дүгнэлт танилцуулах.	НХХ, ЭМТ, ЕБС, СӨББ
БУСАД ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
7	Иргэдэд эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр дарга нар газар дээр нь дараах ажлуудыг 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэх. Үүнд: Эрүүл мэнд, Хүнс, худалдаа, үйлчилгээний бүх чиглэл, үйлдвэрлэл, эмнэлэг, аптек, барилга, байгууламжид хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахад урьдчилсан хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж ажиллах. (Дүнг 05 дугаар сарын 15-нд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.)	ЗДТГ, Нийт байгууллагууд
8	Согтууруулах ундааны хэрэглээнээс шалтгаалж гарч буй гэмт хэрэг, зөрчил, түүний нөхцөл байдлын талаар танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулах.	Цагдаагийн хэлтэс
9	Бизнес эрхлэгчдийн дэмжих зорилгоор согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, борлуулах, үйлчилгээний стандартад өөрчлөлт оруулах асуудлыг судалж танилцуулах.	ЗДТГ, Цагдаагийн хэлтэс
10	Дүүргийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, стандартад хяналт тавьж, дотоод	ЗДТГ, ЭМТ

	орчны ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмолжуулж, хяналт тавьж ажиллах.	
11	Хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн үхэр, хонь, ямааны махыг худалдаалах ажлыг шуурхай зохион байгуулж, хяналт тавих.	ТХҮХ
12	Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа өнгө үзэмжгүй байгууллагын гаднах хаяг, реклам болон хашаа, хайс, эвдэрч гэмтсэн шон, самбаруудыг буулгаж цэгцлэх, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх ажлуудыг газар дээр хяналт тавьж, зөрчлийг арилгуулах ажлаа эрчимжүүлэх.	ТХҮХ Ажлын хэсэг
13	Үерийн эрсдэлтэй бүсэд байгаа айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.	ОБХ, Багахангай ОНӨААТҮГ
14	Үерийн далан сувгийн лаг, хог хаягдлыг цэвэрлэх бэлтгэл ажлыг сайтар хангаж, зохион байгуулах.	ОБХ, Багахангай ОНӨААТҮГ
15	Их хэмжээгээр ус тогтдог байршлуудын судалгааг гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулах.	ОБХ, Багахангай ОНӨААТҮГ
16	Шар усны үерээс урьдчилан сэргийлэх, болзошгүй халдварт өвчнөөс сэргийлж ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах.	ОБХ, ЭМТ, МЭТ
17	Төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс
18	Дүүргийн хэмжээнд газар чөлөөлөлтийн ажлуудыг эрчимжүүлэх.	ГЗБА
19	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг судалж, ажиллах.	СТСХ, ХААА
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
20	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд засаг захиргааны нэгжийн шинэчлэл хийгдэхтэй холбогдуулан тус дүүргийг дүүрэг хэвээр нь авч үлдэх хүрээнд эрх зүй, хууль тогтоомжийг судалж танилцуулах.	ТЗУХ
21	Зорилтот жилийн хүрээнд Фокус уулзалтуудыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар ханган зэргэлдээх сумдын удирдлагуудыг дүүрэгт урьж авчрах.	ЗДТГ
22	Нийтийн тээврийн маршрут нээх ажлын бэлтгэлийг хангах.	ТХҮХ Ажлын хэсэг
23	Түүвэр цэвэрлэгээ хийх ажлаа тогтмолжуулах.	Нийт байгууллагууд
24	Сэг зэм устгах ажлын бэлтгэлийг ханган төсөв тооцоог гарган ажиллах.	Багахангай ОНӨААТҮГ, МЭТ, МЭН
25	Барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангах (Service center), Багахангай тохижилт ОНӨААТҮГ-т ирсэн бульдозрыг ашиглалтад оруулах.	ТХҮХ, Багахангай ОНӨААТҮГ
26	Монгол Улсын Ерөнхий сайд болон Шадар сайдын дүүргийн иргэд, ажилтан, албан хаагчидтай уулзах уулзалтын бэлтгэл ажлыг сайтар хангах.	ТЗУХ, Нийт байгууллагууд
27	Дүүргийн нутаг дэвсгэрийг дайран тээвэрлэлт хийж буй том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Цагдаагийн хэлтэс

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР